

СЭТГҮҮЛЧДИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

ч. Чойсамба *

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор

Түлхүүр үг: сэтгүүлчийн эрх, эрх ашиг, үйлдвэрчний эвлэл, ОНМХ, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ

Сүүлийн жилүүдэд сэтгүүлчдийн эрхийг зөрчих, халдах тохиолдол газар авах төлөвтэй байгаа тул тэдний өмнө эвлэлдэн нэгдэх, дуу хоолойгоо нэгтгэх, хамтын хүчээр эрх ашгаа хамгаалах шаардлага улам ихээр тулгарч байна. 2011 оны 12-р сарын 10-нд хуралдсан Монголын сэтгүүлчдийн XV их хурлаас баталсан МСЭ-ийн дүрэмд «МСЭ нь үйлдвэрчний эвлэлийн чиг баримжаатай байгууллага байна»¹ гэсэн заалт оруулсан нь цаг үеийн шаардлагын илрэл байсан юм.

Монголд өнөөдөр сэтгүүлчид эрх ашгаа хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэж чадаж байна уу? Тэд ҮЭ байгуулах эрхээ эдэлж чадаж байна уу? Эдгээр асуултанд хариулт авахын тулд 32 мэдээллийн хэрэгслийн сэтгүүлчдийг судалгаанд хамрууллаа. Тэд сурвалжлагч, албаны дарга, редактор, ерөнхий редактор, орлогч эрхлэгч, эрхлэгчийн албан тушаалд 1-31 жил ажилласан ажлын туршлагатай байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг төрөлжүүлэн ангилбал телевиз 10 (МОНТВ, «Eagle live-2», «Цаст» Ховдын ТВ, NTV, Оллоо, Bloomberg, С1, «Боловсрол суваг», NBS, «Шинэ дэлхий»), радио 2 (Улаанбаатар FM-101,7, МОНР), сайт 5 (Bataar.mn, Goolingoo.mn, GoGo.mn, Time.mn, Olloo.mn), сонин 9 («Өдрийн сонин», «Өдрийн шуудан», «Ховдын толь», «Эх орны манаа», «Ардчилал», «Үндэсний мэдээ», «Таван цагариг», «Нийслэл таймс», «Хууль зүйн мэдээ»), сэтгүүл 5 («Монголиан экономикс», «Хилчин», TV zone, «Алтангадас»), мэдээллийн агентлаг 1 (МОНЦАМЭ). Түүнчлэн засгийн газрын төв хэвлэл «Засгийн газрын мэдээ», төрийн төв хэвлэл «Ардын эрх» сонинд ажиллаж байсан сэтгүүлчид судалгаанд хамрагдлаа.

Ихэнх мэдээллийн хэрэгсэл шинээр ажилд орж буй сэтгүүлчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулдаг байна. Цөөн тооны сэтгүүлч ажилладаг, цомхон редакциудад хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй зөрчил бий ажээ. Мөн «Хөдөлмөрийн гэрээ байгуулна» гэж ажил олгогч хэлээд байгуулалгүй бүтэн жил тойрдог тохиолдол цөөн боловч

гарч байна. Ерөнхийдөө ХМХ-ийн эзэд буюу ажил олгогч нь ажилтан буюу сэтгүүлчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж хэвшсэн гэж хэлж болно.

Түүнчлэн ихэнх ХМХ-д ажиллаж буй сэтгүүлчдийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал төлөгдөж байгаа нь хэдэн жилийн өмнөх байдалтай харьцуулбал бас нэг дэвшил билээ.

Судалгаанд хамрагдсан 32 мэдээллийн хэрэгслийн 2-т нь (МОНТВ, МОНР) л сэтгүүлчдийн ҮЭ-ийн хороо үйл ажиллагаа явуулж байгаа нь чамлалттай үзүүлэлт юм. «Өдрийн шуудан» сонин 2011 оны 11-р сард ҮЭ-ийн хороогоо байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авч, гишүүдээсээ татвар авч эхэлжээ. Гэвч нэг удаа 5000 төгрөгийн татвар аваад дахиж гишүүнчлэлийн татвар хураагаагүй бөгөөд гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах талаар ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй байна. «Өдрийн шуудан» сонины ҮЭ-ийн хорооны даргаар ажиллаж байсан сэтгүүлч өөр ажилд шилжсэн нь үүнд бүр ч ихээр нөлөөлжээ. Одоо тус сонины сэтгүүлчдээс энэ талаар лавлахад «Манай сонинд ҮЭ ерөөсөө байгаагүй» гэж мэтээр хариулж байна.

«Shuud» телевизийн хамт олон 2013 оны 3-р сард ҮЭ-ийн хороогоо байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авчээ. Гэвч удалгүй тус телевизийг «Eagle» телевизэд нэгтгэж, нэрийг нь «Eagle live-2» гэж өөрчилснөөр удирдлага нь ч солигдсон байна. Шинэ удирдлага нь хуучин нэрээр «Shuud» телевизийн ҮЭ-ийн хорооны идэвхтнүүдийг нэг нэгээр нь дуудан уулзаж: «Манайд ҮЭ байж болохгүй, ҮЭ-ийг бид хүлээн зөвшөөрөхгүй» гэж байр сууриа тодорхой илэрхийлжээ.

Ингэснээр «Shuud» телевизийн ҮЭ-ийн хороо ямар нэг үйл ажиллагаа явуулж чадалгүй өөрөө тарахаас өөр аргагүй байдалд хүрсэн байна. Энэ нь 1991 оны 4-р сарын 19-нд батлагдсан Монгол Улсын «Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай» хуулийн «Үйлдвэрчний эвлэлүүдийн үйл ажиллагааны болон түүний сонгуульт ажилтны эрхийн баталгаа» хэмээх 6 дугаар зүйлийн 1 дүгээр заалтыг («Үйлдвэрчний эвлэлүүдийг захиргааны журмаар тараах, үйл ажиллагааг нь зогсоох, мөшгин хавчих зэргээр үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно») зөрчиж байгаа юм.

Судалгааны явцад сэтгүүлчид ҮЭ-ийн талаар мэдлэг хангалтгүй явдаг нь харагдлаа. Тухайлбал: Хил хамгаалах ерөнхий газраас эрхлэн гаргадаг «Эх орны манаа» сонин, «Хилчин» сэтгүүлд ажилладаг сэтгүүлчид: «Бид тангараг өргөсөн төрийн албан хаагчид учир ҮЭ байгуулж болохгүй» гэсэн ойлголттой явдаг байна.

Сэтгүүлчид эрх ашгаа хамгаалахын тулд эвлэлдэн нэгдэх шаардлага байгаа талаар тэр бүр ярилцдаггүйг судалгаа тогтоолоо. Үүнийгээ тэд: «Бид цаг зав муутай учир энэ тухай ярилцаж амждаггүй» гэж тайлбарладаг. Мөн «ҮЭ-ийн тухай ярьж эхэлбэл эрхлэгч/эзэн таагүй хүлээж авна» гэсэн болгоомжлол, айдас ч байна. Олон сэтгүүлч ҮЭ байгуулах нь ямар ашигтай болох талаар тодорхой ойлголтгүй, төсөөлөл ч үгүй явдаг ажээ.

ҮЭ-тэй болох нь зүйтэй талаар 6-7 редакци, студи дээр яригдаж байсан боловч ярианаас хэтрээгүй байна. Сэтгүүлчид зохион байгуулалтанд орж чаддаггүй бөгөөд ҮЭ-ийн хороо

байгуулахын тулд эзэн (ажил олгогч)-ээс заавал зөвшөөрөл авах шаардлагатай, эсвэл МСЭ-ээс төлөөлөгчид ирж ҮЭ-ийн хороо байгуулах ёстой мэтээр ойлгож явдаг ажээ. Тэгвэл энэ нь «Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай» хуулийн «Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх» 3 дугаар зүйлийн 1 дүгээр заалтаар («Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй») няцаагдаж буй юм.

Энэ талаар МСЭ-ийн ерөнхийлөгч Б.Галларид: «Монголын сэтгүүлчдийн ууган байгууллага МСЭ сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулсан зөрчилтэй тэмцэж чадаж байгаа юу гэвэл чадаж байгаа. Сэтгүүлчдийн мэдлэг чадвар, чадавхийг дээшлүүлэх талаар ажиллаж, төр засгийн өмнө тэдний дуу хоолой, төлөөлөл болж чадаж байна уу гэвэл чадаж байна. Харин сэтгүүлчдийн хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр хүчин мөхөсддөг. Тэгэхээр хэвлэл мэдээллийн салбарт хийвэл зохих хамгийн том өөрчлөлт энд л байна. Үүнийг хууль эрх зүйн хувьд хэн хэрхэн хийх боломжтой вэ гэдэг асуулт гарч ирнэ. Хариулт нь ч тодорхой. Салбарын ҮЭ л энэ чиглэлд дорвитой алхам хийж чадна. Харин

салбарын ҮЭ-г зөвхөн сэтгүүлчид л байгуулж чадна. Намайг ингэж тайлбарлахаар "Тэгвэл тэр ҮЭ-ээ та нар байгуулаад өг л дөө, МСЭ биднийг хамгаалах үүрэгтэй биз дээ" гэж сэтгүүлчид тулгадаг. Бид ҮЭ байгуулах эрх бүхий субъект байсан бол аль эрт үүнийг хийгээд эхэлчих байсан. Салбарын хүчирхэг үйлдвэрчний эвлэлтэй бол МСЭ одоо байгаагаасаа

хэд дахин хүчтэй ажиллах боломжтой, тийм боломжоос татгалзах нь ч тэнэг хэрэг байхсан. Гэвч ҮЭ бол иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж байж хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах хэлбэр юм. ҮЭ байгуулах асуудлыг хөндлөнгөөс зохион байгуулах, тулган

«

Монголд өнөөдөр сэтгүүлчид эрх ашгаа хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэж чадаж байна уу? Тэд ҮЭ байгуулах эрхээ эдэлж чадаж байна уу? Эдгээр асуултанд хариулт авахын тулд 32 мэдээллийн хэрэгслийн сэтгүүлчдийг судалгаанд хамрууллаа.

»

шаардахыг хуулиар хориглосон учраас л өнөөдрийг хүртэл МСЭ энэ асуудалд оролцож чадахгүй, гагцхүү зөвлөмж өгөх, сануулах уриалах төдий үүрэгтэй байгаа юм»² гэж бичсэн байдаг.

Мөн ҮЭ-ийн гишүүн болсноор ажил олгогчийн зүгээс ямар нэг дарамт шахалтанд орно, цаашлаад ажилгүй болно гэсэн айдас сэтгүүлчдийн дунд түгээмэл байна. Ингэсэн тохиолдолд ажил олгогч «Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай» хуулийн «Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх» 3 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг («Үйлдвэрчний эвлэлийн гишүүн мөн эсэхтэй холбогдуулан иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах буюу тэднийг ялгаварлан гадуурхахыг хориглоно») зөрчих юм.

Залуу сэтгүүлчид ҮЭ-ийн тухай яриа өрнүүлэхийг карьерт халтай гэж үздэг учир энэ сэдвийг аль болох тойрч өнгөрдөг байна. Харин байр сууриа бэхжүүлсэн, олон жил ажилласан сэтгүүлчид энэ тухай ярьдаг боловч мөн л зохион байгуулалтанд орж чаддаггүй, ярианаас хэтэрдэггүй ажээ.

Албаны дарга, орлогч эрхлэгч, эрхлэгч нараас «Танай ажил дээр сэтгүүлчид ҮЭ-ийн хороо байгуулбал та хэрхэн хүлээж авах вэ?» гэсэн асуултанд ихэвчлэн «Миний зүгээс эсэргүүцэх зүйл үгүй. Байгуулагдсан тохиолдолд эзэн л мэдэж шийдэнэ» гэсэн хариулт өгч байлаа. «Тэгвэл эзэн яаж хандах бол?» гэсэн асуултанд тэд хоёр төрлийн хариулт өгч байна. Эзэн нь улс төрөөс хол хөндий, редакци, студийн өдөр тутмын ажилд тэр бүр хутгалдаад байдаггүй бол төдийлөн эмзэглэж хүлээж авахгүй гэж ХМХ-ийн удирдах албан тушаалтнууд үзэж буй юм. Харин улс төрч эзэн өөрийнх нь эзэмшдэг ХМХ-ийн сэтгүүлчид ҮЭ-ийн хороо байгуулахыг хэрхэвч хүлээн зөвшөөрөхгүй гэж тэд хариулжээ.

ҮЭ-ийн хороо байгуулахаар хөөцөлдсөн сэтгүүлчийг ажил олгогч дарамтлах тохиолдол гардаг байна. «Боловсрол суваг» телевизийн өмнөх дарга 5 жилийн өмнө ҮЭ-ийн хороо байгуулахаар идэвх санаачилга гаргаж, хөөцөлдөж эхлэхэд: «Чи яасан их завтай юм бэ? Урдах ажил чинь багадаад байна уу?» гэх мэтээр дарамталжээ. Одоо тэр дарга өөр ажилд шилжсэн байна.

32 мэдээллийн хэрэгслийн 40 гаруй сурвалжлагч, албаны дарга, редактор, ерөнхий редактор, орлогч эрхлэгч, эрхлэгч нартай уулзаж ярилцахад

өнөөгийн нөхцөл байдалд сэтгүүлчид эвлэлдэн нэгдэж, ҮЭ-ийн хороо байгуулж, эрх ашгаа хамгаалах боломж тун хомс байгаа нь харагдсан юм.

«Монголын сэтгүүл зүй өнөөдөр үндсэндээ хувийн хэвшил дээр суурилж байна. Ажил олгогч, эздийн хувьд аль болох бага зардлаар их ашиг олох сонирхолтой байдаг нь нууц биш. Сэтгүүл зүйн салбарт хөрөнгө оруулагчид ч мөн л ашгийн төлөө ажиллаж байгаа учраас ажиллагсад аль болох бага цалин өгч, нийгмийн асуудалд нь аль болох бага зардал зарцуулахыг хичээдэг. Харин ҮЭ байгаа газарт ажиллагсад түүгээр дамжуулан эзэртэйгээ хэлэлцээрт орж, хамтын гэрээ байгуулж, хөнгөлөлт эдлэх боломжтой болдог. Ажлын байраа хууль ёсоор баталгаажуулж, хөдөлмөрлөх эрх ашгаа хамгаалуулж, хийсэн ажилдаа тохирсон хөлс авах боломжтой болно. ҮЭ-ийн хамгийн давуу тал нь босоо тогтолцоо бүхий хүчирхэг бүтэц бөгөөд хуулиар сайтар хамгаалагдсан учраас хүчтэй, зоригтой ажиллаж, хүссэн үр дүндээ хүрэх бодит боломжтой юм. Монголын сэтгүүлчид бусдын эрх ашгийг хамгаалахын төлөө, шударга үнэний төлөө, нийгмийн сайн сайхны төлөө цаг наргүй хөдөлмөрлөх атлаа өөрсдийн эрх ашгаа хамгаалах, хүчирхэг үйлдвэрчний эвлэлтэй болох талаар өдийг хүртэл дорвитой ажиллаж чадахгүй байгаа нь манай салбарт ҮЭ-ийн хүчтэй манлайлагч үгүйлэгдэж байгаатай, мөн хувь сэтгүүлчид ҮЭ-ийн ач холбогдлыг ойлгохгүй ойшоохгүй байгаатай, эвлэлдэн нэгдэж эрх ашгаа хамгаалах туршлага байхгүйтэй, өөрсдийн хувь заяаг өрөөлд даатгаж хэн нэгэн өмнөөс нь диваажин байгуулж өгөхийг хүсдэг хэрэглээний сэтгэ-

хүйтэй нь холбоотой гэдгийг хэлмээр байна»³.

Сэтгүүлчид ҮЭ-ийн хороо байгуулснаар өөрсдийн өмнө тулгамдсан олон асуудлыг редакци, студи дотроо, дугуй ширээний ард албан олгогчтойгоо сууж байгаад шийдвэрлэж чадна. Тухайлбал:

- Сэтгүүлч ба ОНМХ-ийн салбарын бусад ажилтны хөдөлмөрийн болон нийгэм-эдийн засгийн бусад эрх ашгийг хангах зорилгоор хөдөлмөрийн гэрээ байгуулах,

- Ажлын байрыг хамгаалах,

- Цалин хөлсийг хянах,

- Ажил олгогчтой хамтын гэрээ байгуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих,

- Сэтгүүлчдийн мэдлэг, мэргэжлийг байнга дээшлүүлэх,

- Үүрэгт ажлаа гүйцэтгэх явцдаа золгүй тохиолдолд өртсөн бол даатгал авах,

- Хөдөлмөрийн эрх ашгаа хамгаалуулахдаа хууль зүйн үнэгүй зөвлөгөө авах,

- ҮЭ-ийн сан байгуулах (ажилгүйдлийн, даатгалын, мэргэжил дээшлүүлэх г. м.).

Түүнээс гадна:

- ОНМХ-ийн үйл ажиллагааг зохицуулсан хууль батлахад сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс санал оруулах,

- ҮЭ-ийн гишүүдийн эрх ашгийг тууштай хамгаалсан хууль батлуулахад нөлөөлөх боломжтой.

Байнгын ажиллагаатай байгаа МҮОНТ-ийн ҮЭ-ийн салбар хороо гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах тал дээр ямар ямар ажил хийснийг товчхон өгүүлье. Тус хороо нь 3

жилийн хугацаатай сонгогддог 5 тэргүүлэгч гишүүнээс бүрддэг, жилийн төлөвлөгөөгөө хамт олноороо хэлэлцүүлж батлуулдаг бөгөөд тодорхой хуваарийн дагуу хийж гүйцэтгэдэг байна.

Хороо нь Телевизийн захирлын дэргэдэх зөвлөлд өөрийн хоёр төлөөлөлтэй. Мөн Захирлуудын зөвлөлийн хуралд шаардлагатай үед суудаг. Түүнээс гадна Үндэсний зөвлөлийн хуралд, ялангуяа төсөв, төлөвлөгөө хэлэлцэх үед оролцдог. Энэ нь уран бүтээлийн тогоон доторх зовлон жаргалыг ойлгуулах, сэтгүүл зүйн хөрсөнд зөв буулгахад чухал үүрэгтэй. Захиргаа ямар асуудал хэлэлцэж байгааг мэдэж байх нь давуу тал юм. Энэ нь Захиргааны шийдвэрийг хянах бололцоог ҮЭ-ийн хороонд олгодог. Тухайлбал: цалин хөлсийг тухайн жил нэмэхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд ажилчиддаа ямар бололцоо гаргаж болохыг эрэлхийлэх, улмаар ямар асуудлаар захиргаанд шаардлага тавьж болохыг ҮЭ-ийн хороо судалдаг ажээ.

Хороо нь гишүүдийн нийт татварын 70 хувийг үйл ажиллагаандаа зарцуулах эрхтэй бөгөөд үлдсэн 30 хувийг МААХҮЭХ-нд гишүүнчлэлийн татварт төлдөг. МҮОНТ-ийн ҮЭ-ийн салбар хороо хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулах тал дээр түлхүү анхаарч ажилладаг. Хөдөлмөрийн хуулийг үндэс болгохын сацуу байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээг сайжруулах үндсэн нөхцлөөр хамтын гэрээг байгуулах ёстой гэж МҮОНТ-ийн ҮЭ-ийн салбар хороо үздэг. Энэ гэрээнд үйлдвэрчний байгууллага ихээхэн ач холбогдол өгч, зарчмын

асуудлуудаар байр сууриа тусгадаг, тэгэхдээ халамжийн асуудалд түлхүү анхаардаг. Харин хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа байгууллагын онцлог, хөдөлмөрлөх нөхцөл, цалин хөлс, шагнал урамшуулал, норм, зэрэг дэвийн шагнал урамшуулал зэрэгт зөвлөгөө өгч, нөхцөл сайжруулах гарцыг урьдчилан хайдаг байна. ҮЭ-ийн гишүүн нь захиргаатай хөдөлмөрийн гэрээ байгуулахад ҮЭ-ийн төлөөлөл байлцаж, шаардлагатай гэж үзвэл гэрээ байгуулахыг түр зогсоодог. Хамтын болон хөдөлмөрийн гэрээ байгуулах явцыг тухайн гишүүн өөрийн авьяас чадварыг үнэлж, даргатайгаа ижил түвшинд байх ганц өдөр гэж МҮОНТ-ийн ҮЭ-ийн салбар хороо үздэг учир ихээхэн ач холбогдол өгдөг ажээ. Түүнчлэн холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, хамтын гэрээний заалтууд хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж ажилладаг.

МҮОНТ-ийн ҮЭ-ийн гишүүн байх нь эгзэгтэй үед эрхээ хамгаалуулах давуу нөхцөл болдог. Гишүүнийх нь эрх хөндөгдөж буй тохиолдолд ҮЭ болсон үйл явдалд хөндлөнгийн байр сууринаас оролцож, үнэлэлт дүгнэлт өгдөг байна. ҮЭ-ийн хороо гишүүддээ эрхийг нь ойлгуулах тал дээр олон ажил зохион байгуулдаг. Шаардлагатай тохиолдолд ҮЭ-ийн төв байгууллагаасаа буюу МҮЭХ-ноос хууль эрх зүйн чиглэлээр зөвлөгөө авдаг.

МҮОНТ-ийн ҮЭ-ийн хороо захиргаатайгаа ойлголцолд хүрч, хамтран ажилласны үр дүнд ажилтнууд үнэ төлбөргүй эмнэлгийн үзлэгт хамрагдаж, хоолны хөнгөлөлт эдэлж, амралтын эрхийн бичгээр шагнуулж, илүү цагийн хөлс болон буцалтгүй тусламж авч байна.

Эцэст нь дүгнэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнууд хараат бус үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхтэй боловч энэхүү эрхээ бодит амьдрал дээр эдэлж чадахгүй байна.

Ишлэл

¹ Монголын сэтгүүлчдийн XV их хурлын материал. 2011 оны 12-р сарын 10.

² Галаарид Б. Сэтгүүлчид хэвлэл мэдээллийн салбарын өөрчлөлт шинэчлэлийн эзэд нь байж чадах уу? // http://galaarid.blogspot.com/2013/05/blog-post_6.html

³ Мөн тэнд.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Монгол Улсын «Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай» хууль.

2. Монгол Улсын «Хөдөлмөрийн тухай» хууль.

3. Галаарид Б. 2013. Сэтгүүлчид хэвлэл мэдээллийн салбарын өөрчлөлт шинэчлэлийн эзэд нь байж чадах уу? // galaarid.blogspot.com/2013/05/blog-post_6.html

4. Цэрэнжав Д. 2011. Хэвлэл мэдээллийн эздийн амьдрах эрх // ajiglagch.niitlech.mn/content/3625.shtml

5. Чойсамба Ч. 2008. Сэтгүүлчдийн эрхийг хамгаалахад ҮЭ-ийн гүйцэтгэх үүрэг // «Сэтгүүл зүй» МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №9/307.

Резюме

В статье автор затрагивает проблемы деятельности профсоюзов работников СМИ Монголии. На основе обобщения результатов исследования, в котором приняли участие журналисты 32 газет, журналов, телевидений, радио, веб-сайтов и информационного агентства, автор воссоздаёт реальную картину, сложившуюся в монгольских масс-медиа. Исследование выявило полное отсутствие реально функционирующих профсоюзов в журналистской среде (за исключением Национального общественного телевидения и радио), страх за возможную потерю работы и мн. др.